



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/174

Есөнбулаг сум

Аймгийн аюулгүйн нөөцөөс
Тонхил, Бугат, Цогт сумдад өвс, тэжээл
үнэгүй олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, Онцгой комиссын 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлээс өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдлыг харгалзан Цогт сумд 1700 боодол өвс, 100 уут тэжээл, Бугат сумд 1700 боодол өвс, 100 уут тэжээл, Тонхил сумд 1600 боодол өвс, 100 уут тэжээл нийт 5000 боодол буюу 100 тн өвс, 300 уут тэжээлийн үнийг чөлөөлж олгосугай.

2.Хуваарийн дагуу олгосон өвс, тэжээлийг зориулалтын бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчил гаргуулахгүй ажиллахад хяналт тавьж, дүнг танилцуулахыг холбогдох сумдын Засаг дарга, Цагдаагийн газар (Д.Бүрэнбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

3. Үнэ чөлөөлсөн өвс, тэжээлийг нягтлан бодох бүртгэлээс хасаж тооцохыг Засаг даргын Тамгын газар (Н.Наранцэцэг)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

